

# ДОТООДЫН

**ЗАХ ЗЭЭЛИЙН ДОЛОО  
ХОНОГИЙН ТОЙМ**



2025.02.03



## Дотоодын зах зээлийн онцлох мэдээ

## ТОВЧ

- ТОП-20 индекс дээд ханшаа шинэчилж 52,345 төгрөгт хүрлээ.
- ТОП-20 индекс энэ оны эхний сард 2.05% өслөө.
- 2-р сарын 5-нд ГОЛОМТ БАНК ХК-ийн 4-р улирлын тайлангийн Earnings Call болно.
- Хаан Банк ХК 2024 оны жилийн эцсийн санхүүгийн аудитлагдаагүй тайлангаа зарлалаа.

## МХБ-ийн индексийн өгөөж

Индекс	Долоо хоног	Сар	Жил
ТОП 20	0.79%	2.05%	25.47%
MSE A	0.74%	1.95%	20.27%
MSE B	0.31%	3.99%	34.89%

2025/01/27 – 2025/01/31

## Идэвхтэй арилжаалагдсан үнэт цаас

Симбол	Үнийн дүн
KHAN	630,431,793.00
BOGD	341,621,731.67
GLMT	224,204,318.00
APU	161,407,060.26
MSE	149,949,801.86

2025/01/27 – 2025/01/31

## Өндөр өсөлттэй үнэт цаас

Симбол	Хаалтын ханш	Өсөлт %
HBZ	6,000.00	20.00%
NKT	93.15	15.00%
BHG	1,557.00	14.99%
HNS	4,772.00	14.99%
JLT	64.40	14.98%

2025/01/27 – 2025/01/31

2025 он 02-р сарын 03

Зах зээлийн  
үнэлгээ тэрбум ₮

13,227

ТОП-20 индекс

52,345

MSE A

20,182

MSE B

15,803



## МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

ДНБ өсөлт

5.0%

2024-III улирал

Инфляц

9.0%

2024-12 сар

ГВУН(сая\$)

5,509

2024-12 сар

Бодлогын  
хүү

10.0%

ЗГ-ын бондын  
өгөөж

6.92%

USD/MNT

3,448.24

2025-02-02



## Хөрөнгийн зах зээлийн мэдээлэл

### ХААН БАНК IPO ЗАРЦУУЛАЛТАА ТАЙЛАГНАЛАА



"Хаан банк" ХК 2023 оны 4 дүгээр сарын 13-19-ний хооронд олон нийтэд 959 төгрөгийн нэгж үнэ бүхий 191,219,800 ширхэг энгийн хувьцааг санал болгож, нийт 183,379,788,200.00 төгрөгийг татан төвлөрүүлсэн байна. Татан төвлөрүүлсэн хөрөнгийг үр ашигтай зарцуулж, банкны үйл ажиллагааг шинэ шатанд гаргах зорилгоор дараах зарцуулалтуудыг хийжээ:

- Мэдээллийн технологийн хөрөнгө оруулалт: 16%
- Цахим бүтээгдэхүүний хөгжүүлэлт, сайжруулалт: 19%
- Ногоон төсөл, хөтөлбөрүүдийн санхүүжилт: 34%
- Урт хугацаат зээл (Орон сууц, хөрөнгө оруулалтын санхүүжилт): 31%

### ТҮМЭН ШУВУУТ ХК 2024 ОНД 143.8 САЯ ШИРХЭГ ӨНДӨГ ҮЙЛДВЭРЛЭЖЭЭ


Түмэн Шувуут ХК-ийн танилцуулсан 2024 оны үйл ажиллагааны тайланд дэгдээхэйн 2 байр, өндөглөгч тахианы 4 байр нь бүрэн баригдаж, үйлдвэрлэл явуулах бэлтгэлээ хангаад буйг дурджээ. Тус компани 2024.12.04-нд "Түмэн шувуут-3" аж ахуйн дэгдээхэйн 1 байрыг ашиглалтад оруулж, 50 мянган дэгдээхэйг хүлээн авсан байна. Мөн "Түмэн шувуут" ХК-ийн Гүйцэтгэх захирал Ж.Болд, 2024 онд 143.8 сая ширхэг өндөг үйлдвэрлэсэнээ мэдээлжээ.

### ГОЛОМТ БАНК ХК-ИЙН EARNINGS CALL 2-Р САРЫН 5-НД БОЛНО



Голомт банк 2024 онд 406.7 тэрбумын цэвэр ашигтай ажилласан нь өмнөх жилээс 124.9 хувиар өсөв. Харилцагчдаас татсан эх үүсвэр 8.5 их наяд төгрөг болсон бол хүүгийн орлого 1.2 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 35.1 хувиар нэмэгджээ. Тэгвэл Голомт Банк ХК-ийн Гүйцэтгэх захирал А.Одонбаатар 2024 оны IV улирлын үйл ажиллагаа, санхүүгийн тайлангаа хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагч, үнэт цаасны шинжээч нарт 2-р сарын 5-ны 11:00 цагаас CMM Analyst Network-тай хамтран "Earnings Call" хэлбэрээр танилцуулах гэж байна.

### График 1. МХБ-ын ТОП-20, MSE-A, MSE-B индексүүдийн гүйцэтгэл



Эх сурвалж. Монголын Хөрөнгийн Бирж



## ТОП-20 индекст багтах компаниудын 2024 оны жилийн эцсийн тайлан


2024 оны шинэчилсэн ТОП-20 индексийн багцад өмнөхөөс 17 компани хэвээр үлдэж, харин "Сэндли ББСБ" ХК, "Монос хүнс" ХК, "Газар шим үйлдвэр" ХК хасагджээ. Тэдний оронд "Хас банк" ХК, "Ард санхүүгийн нэгдэл" ХК, "Лэндмн ББСБ" ХК шинээр багтан, индексийн бүрэлдэхүүнд өөрчлөлт ороод байгаа билээ. Тэгвэл ТОП-20 индекст багтах компаниуд санхүүгийн аудитлагдаагүй тайлангаа танилцуулсаар байна.

### АРД КРЕДИТ ББСБ ХК-Н АШИГ 43.3% ӨСЛӨӨ




Компанийн цэвэр ашиг 3.6 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 43.3%-иар өссөн байна. Нийт актив буюу хөрөнгийн хэмжээ 115.8 тэрбум төгрөгт хүрч, 61%-иар нэмэгдсэн бол хувьцааны ханш 3.25%-иар буурсан ч компанийн үнэлгээ 42.2 тэрбум төгрөгт хүрч, 25.7%-иар өсжээ. Энэ өсөлт нь 2024 онд 84 сая шинэ хувьцаа гарган FPO хийсэнтэй холбоотой юм.

**График 2. Цэвэр ашиг**  
(тэрбум төгрөг)



**График 3. Үнэ ашгийн харьцаа P/E**




- Нийт актив: 115.8 тэрбум төгрөг (+61%)
- EPS (нэгж хувьцаанд ногдох ашиг): 10
- P/E (үнэ ашгийн харьцаа): 11.7
- ROE (Өөрийн хөрөнгийн өгөөж): 12.5%
- P/B (Өөрийн хөрөнгийн харьцаа): 1.1

### ХААН БАНК ХК-Н НЭГЖ ХУВЬЦААНД НОГДОХ АШИГ 334 ТӨГРӨГ




Хаан банк 2024 оны жилийн эцсийн байдлаар 639 тэрбум төгрөгийн ашигтай ажиллаж, нэгж хувьцаанд ногдох ашиг нь 334 төгрөг болсон байна. 2024 оны ногдол ашиг олгох тухай шийдвэрийг 2025 оны 2-р сарын 13-ны өдөр ТУЗ-ийн хурлаар хэлэлцэж, шийдвэрлэх болно. Мөн банкны чанаргүй зээлийн харьцаа 4.3% хүртэл буурсан нь санхүүгийн тогтвортой байдлын сайн илрэл юм.

**График 4. Цэвэр ашиг**  
(тэрбум төгрөг)



**График 5. Чанаргүй зээлийн харьцаа**



Нийт хөрөнгийн хэмжээ 20,303 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 17 хувиар өссөн нь Хаан банкны санхүүгийн хүчин чадал, хөрөнгө оруулалтын үр ашигтай байдлын өсөлтийг илтгэж байна.



## ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН СОНГОЛТ ХЭРХЭН ХИЙХ ВЭ?

График 6. МХБ-ын ТОП-20 индекст багтах компаниудын ногдол ашгийн өгөөж (2024У2)





График 7. МХБ-ын ТОП-20 индекст багтах компаниудын үнэлгээний матриц (2024У2)



\*Үнэ-ашгийн харьцаа (P/E) нь компанийн үнэлгээ зах зээлийн хүлээлттэй хэр нийцэж байгааг харуулдаг бол ногдол ашгийн өгөөж (DY) нь хөрөнгө оруулагчдад шууд орлогын эх үүсвэр болдог. Иймд хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахдаа P/E болон DY-ийн тэнцвэрийг харгалзан үзэх нь зах зээлийн эрсдэлийг удирдаж, өгөөжийг оновчтой болгоход чухал ач холбогдолтой.